



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2026 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

ХҮН намын даргыг бүртгэж, намын
дүрэм (Шинэчилсэн найруулга)-ийг
бүртгэхээс татгалзах тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, Н.Батзориг, М.Батсуурь, Б.Батцэрэн, Н.Батчимэг, Н.Баярмаа, Э.Золзаяа, Ц.Оч, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Ундрах, Б.Цогт, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

ХҮН намын дарга болон дүрэм (Шинэчилсэн найруулга)-ийг бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч Б.Ундрах илтгэж, танилцуулав.

ТОДОРХОЙЛОХ нь:

ХҮН намын дарга Т.Доржхандаас “Намын ээлжит Их хурлаар намын даргын бүрэн эрхийн хугацааг 4 жилээр сунгаж шийдвэрлэсэн тул намын даргаар томилсон шийдвэр, баримт бичгийн бүрдлийг хангаж хүргүүлснийг, мөн намын дүрэм (Шинэчилсэн найруулга)-ийг бүртгүүлэх” тухай өргөдлийг 172 хуудас баримт, 1 ширхэг флашны хамт 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Улсын дээд шүүхэд ирүүлжээ.

Өргөдөл, түүнд хавсаргасан баримт болон нэмэлтээр ирүүлсэн 10 хуудас баримт нь Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д нийцэж байгаа эсэхийг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын 2.5-д заасны дагуу шалгаж, журмын 6.6-д зааснаар нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас дараах үндэслэлээр ХҮН намын даргаар Тогмидын Доржхандыг бүртгэж, намын дүрэм (Шинэчилсэн найруулга)-ийг бүртгэхээс татгалзаж шийдвэрлэлээ.

Нэг.Намын удирдах дээд байгууллага болох Их хурлыг зарлан хуралдуулсан процессын талаар:

Улсын дээд шүүхэд бүртгэлтэй, ХҮН намын дүрэм (2022 он)-ийн 4.5-д “Намын ээлжит Их хурлыг 4 жилд 1 удаа хуралдуулна. Их хурлыг хуралдуулах шийдвэрийг

30-аас доошгүй хоногийн өмнө намын Удирдах зөвлөлөөс гаргана” гэж тус тус заажээ.

Өргөдөлд хавсаргасан баримтаас үзэхэд, тус намын Удирдах зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 13/25 дугаар тогтоолоор “ээлжит VIII Их хурлыг 2025 оны 12 дугаар сарын 13-ны өдөр”, харин 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 15/25 дугаар тогтоолоор “Төлөөлөх зөвлөлийн хурлыг 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдөр” хуралдуулахаар товыг тогтоож, улмаар журамд заасан хугацаанд хурлын товыг намын гишүүд, төлөөлөгчдөд намын цахим хуудсаар дамжуулан хүргэж, мэдэгдсэн байна.

ХҮН намын 2025 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн ээлжит VIII Их хуралд 213 төлөөлөгч оролцохоос 164 төлөөлөгч (77 хувь) оролцсон, үүнээс орон нутгийн 60 төлөөлөгч (36.6 хувь) байна.

1.1. Намын даргыг бүртгэсэн талаар:

Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 15 дугаар зүйлийн 15.3-т “Намын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, намын даргыг томилсон шийдвэрийг 60 хоногийн дотор Улсын дээд шүүхэд албан ёсоор хүргүүлнэ”, 17 дугаар зүйлийн 17.6-д “Намын дүрэмд заасны дагуу намын даргыг удирдах дээд байгууллага, эсхүл төлөөллийн төв байгууллага, ... сонгоно” гэж;

ХҮН намын дүрэм (2022 он)-ийн 1.3.3-т “Зохион байгуулалт, үйл ажиллагаагаа ардчилсан зарчимд тулгуурлан цөөнхийн саналд хүндэтгэлтэй хандаж, олонхын саналаар гаргасан шийдвэрийг нийтээрээ даган биелүүлж, эв нэгдлийг эрхэмлэн ажиллах” зарчмыг баримтлах бөгөөд 4.8-д “Намын Их хурлыг нийт төлөөлөгчдийн олонх нь оролцсоноор хүчинтэйд тооцно”, 4.9-д “Намын Их хурал нь дараах онцгой бүрэн эрхтэй:”, 4.9.4-т “Намын даргыг сонгох, чөлөөлөх”, 5.8-д “Намын төлөөлөх зөвлөл нь дараах бүрэн эрхтэй:”, 5.8.2-т “Намын даргад нэр дэвшигчийг тодруулах, чөлөөлөх саналыг Их хуралд оруулах”, 5.12-т “Тодорхой асуудлыг шийдэх зорилгоор намын Удирдах зөвлөлийн шийдвэрээр ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно ...”, 6.2-т “ХҮН намын даргыг 4 жилийн хугацаагаар сонгох ...” гэж тус тус заасан байна.

Монгол Улсын дээд шүүхийн 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар тогтоолоор Тогмидын Доржхандыг ХҮН намын даргаар бүртгэсэн.

Өргөдөлд ирүүлсэн баримтуудаар, намын Удирдах зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 16а/25 дугаар тогтоолоор ХҮН намын дарга болон хариуцлагын хорооны дарга, гишүүнд нэр дэвшигчдийг тодруулах ажлыг зохион байгуулах хороо байгуулагдаж, намын даргад нэр дэвшигчийг бүртгэхэд нэг хүн буюу намын даргаар ажиллаж буй Т.Доржханд санал ирүүлснийг Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, Төлөөлөх зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн Т/20 дугаар тогтоолоор ХҮН намын дарга Тогмидын Доржхандын хугацааг 4 жилээр сунгах саналыг намын Их хуралд оруулахаар шийдвэрлэжээ.

ХҮН намын ээлжит VIII Их хурал 2025 оны 12 дугаар сарын 13-ны өдөр хуралдаж, ИХ/05 дугаар тогтоолоор нийт 4 асуудал хэлэлцэхээр баталсны дотор намын даргын бүрэн эрхийг хугацааг сунгах асуудал багтсан байна. Намын даргын бүрэн эрхийн хугацааг 4 жилээр сунгах асуудлыг хэлэлцэх хуралдаанд 164

төлөөлөгч оролцсон боловч нууц санал хураалтын дүнгээр 162 төлөөлөгчийн саналын хуудас тоологдсон. Үүнээс 2 саналын хуудас хүчингүй, 146 буюу 91.3 хувь нь дэмжсэн, 9 буюу 6 хувь нь татгалзсан, 5 буюу 3 хувь нь түдгэлзсэн. Ийнхүү ИХ/06 дугаар тогтоолоор ХҮН намын дарга Т.Доржхандын бүрэн эрхийн хугацааг 4 жилээр сунгахыг намын ээлжит Их хурлын нийт 162 төлөөлөгчийн 91.3 хувийн саналаар баталсан, өөрөөр хэлбэл, Их хуралд оролцсон төлөөлөгчийн олонхын саналаар тухайн асуудлыг шийдвэрлэсэн нь хуулийн 8.2.1, 8.3, 17.6, намын дүрмийн 1.3.3, 4.8, 4.9.4, 6.2-т заасантай нийцсэн гэж үзлээ.

Иймд ХҮН намын ээлжит VIII Их хурлаар намын даргын бүрэн эрхийн хугацааг сунгасан үйл ажиллагаа нь хууль, дүрмийн холбогдох заалтыг зөрчөөгүй байх тул тус намын даргаар Т.Доржхандыг бүртгэхээр шийдвэрлэв.

Хоёр. Намын шинэчилсэн дүрмийг бүртгэхээс татгалзсан тухайд.

ХҮН намын 2025 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн ээлжит VIII Их хурлаар баталсан намын дүрэм (Шинэчилсэн найруулга)-ийг дараах үндэслэлээр бүртгэхээс татгалзав.

Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Намын бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог энэ хуульд заасны дагуу намын дүрмээр зохицуулна”, 15.2-т “Намын дүрэмд дараах нийтлэг зүйлийг тусгана:” гээд 15.2.1-15.2.10-т намын дүрэмд тавигдах шаардлагыг тодорхойлсон.

2.1.Хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-т “Намын хяналтын байгууллага хараат бусаар ажиллах бөгөөд түүний үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно, 18.4-т “Намын хяналтын байгууллага дараах маргааныг хянан шийдвэрлэж, шийдвэртээ үндэслэлээ тодорхой бичнэ.” 18.4.1-д “намын дүрэм зөрчсөн эсэх”, 20 дугаар зүйлийн 20.3-т “Намын гишүүнээс хасах асуудлыг тогтоосон журмын дагуу намын хяналтын байгууллага шийдвэрлэнэ”, 20.4-т “Намын дүрмийг санаатай зөрчсөн, эсхүл намын үнэт зүйл, зарчмыг ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд намын гишүүнээс хасахыг хориглоно” гэж тус тус заасан.

ХҮН намын дүрмийн 7.4-т “Намын дүрмийн 5.2.4, 5.2.7, 5.2.9, 5.2.10-т заасан намын гишүүний үүргийг санаатай зөрчсөн намын гишүүнийг гишүүнчлэлээс хасах асуудлыг энэхүү дүрмийн 8-р бүлэгт заасан намын хяналтын байгууллага шийдвэрлэнэ ...” гэж заасан атлаа 7.1-д “Энэхүү дүрмийн 5.2-т заасан намын гишүүний үүргээ биелүүлээгүй гишүүнд сануулах, намаас төрийн улс төрийн албан тушаалд болон сонгуульд нэр дэвшүүлэхээс татгалзах, намаас улс төрийн дэмжлэг үзүүлэхээс татгалзах сахилгын шийтгэлийг тухайн анхан, дунд шатны намын байгууллагын тэргүүлэгчдийн хурлын шийдвэрээр ногдуулна” гэсэн нь ойлгомжгүй, дүрмийн дээрх заалтууд хоорондоо зөрчилтэйгөөс гадна намын хяналтын байгууллага сахилгын шийтгэл ногдуулах асуудлыг шийдвэрлэхээр байхад анхан, дунд шатны намын байгууллагын Тэргүүлэгчдийн хурлын шийдвэрээр шийтгэл ногдуулахаар дүрмийн 7.1-д заасан нь хуулийн 18.3-т нийцэхгүй байна.

2.2.Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4-т “намын удирдах дээд байгууллага, төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллага, хяналтын байгууллага болон бусад байгууллага, тэдгээрийн бүрэлдэхүүн, бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээ, хуралдуулах, шийдвэр гаргах журам”-ыг намын дүрэмд тусгахаар заасан.

ХҮН намын дүрмийн 12.2-т “Төлөөлөх зөвлөлийн бүрэлдэхүүнд албан тушаалын зарчмаар намын дор дурдсан сонгуульт гишүүд орно.” гээд 12.2.1-12.2.7-д албан тушаалын зарчмаар орох бүрэлдэхүүнийг заажээ. Харин дүрмийн 12.4-т “Тухайн намын байгууллагаас сонгуулийн зарчмаар сонгогдсон төлөөлөгчдийн тоо нь албан тушаалын зарчмаар сонгогдсон төлөөлөгчдийн тооноос хэтрэхгүй ...” гэснээс үзэхэд Төлөөлөх зөвлөлийн бүрэлдэхүүн нь хэдэн хүний бүрэлдэхүүнтэй байх нь ойлгомжгүй, албан тушаалын болон сонгогдох төлөөлөгчдийн тоог хэдээр тогтоож байгаа нь тодорхойгүйгээс гадна хуулийн дээрх шаардлагад нийцэхгүй байна. Дурдсан нөхцөл байдлыг намын дүрэмд тодорхой тусгах шаардлагатай юм.

2.3.Хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Энэ хуулийн 16.1-д заасан байгууллагыг бүрдүүлэхдээ дараах шаардлагыг хангана:” гээд 8.2.1-д “нууц санал хураалт явуулах”, 8.2.2-т “гишүүдийн оролцоо, ил тод байдлыг хангах”, 8.2.3-т “нэр дэвшүүлэхдээ аль нэг хүйсийн төлөөлөл 30 хувиас доошгүй байх”, 17 дугаар зүйлийн 17.5-д “Намын дүрэмд заасны дагуу намын удирдах дээд байгууллага, эсхүл төлөөллийн төв байгууллага нь намын гүйцэтгэх төв байгууллагыг дөрвөн жилээс илүүгүй хугацаагаар сонгоно. Гүйцэтгэх төв байгууллага нь гурваас доошгүй тооны гишүүнтэй байна” гэж заасан.

Намын дүрмийн 15.1-д “Намын өдөр тутмын ажлыг эрхлэх чиг үүрэг бүхий намын гүйцэтгэх төв байгууллага нь Гүйцэтгэх зөвлөл бөгөөд тус зөвлөлийг Ерөнхий нарийн бичгийн дарга удирдана”, 15.3-т “Ерөнхий нарийн бичгийн даргыг Намын даргын санал оруулснаар, нарийн бичгийн даргыг Ерөнхий нарийн бичгийн даргын санал оруулснаар намын Төлөөлөх зөвлөлөөс 4 хүртэл жилийн хугацаанд томилно”, 15.2-т “Гүйцэтгэх зөвлөл нь Ерөнхий нарийн бичгийн дарга, нарийн бичгийн дарга нар, намын санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтан болон газар, хэлтсийн дарга нараас бүрдэх бөгөөд эдгээр албан тушаалтан нь Гүйцэтгэх зөвлөлийн гишүүн байна. Гүйцэтгэх зөвлөлийн гишүүдийн тоо 25-аас хэтрэхгүй байхаар Ерөнхий нарийн бичгийн дарга Гүйцэтгэх зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүнийг батална” гэж тус тус заажээ.

Дүрмийн дээрх зохицуулалтаас үзэхэд, намын Гүйцэтгэх зөвлөлийн бүрэлдэхүүний тоог тодорхой заагаагүй гэж үзнэ. Учир нь, дээд хязгаарыг “25-аас хэтрэхгүй” гэж заасан ба доод хязгаар нь хэд болох нь тодорхойгүй, хуульд нууц санал хураалтаар сонгохоор заасан байхад Ерөнхий нарийн бичгийн дарга, нарийн бичгийн даргыг Төлөөлөх зөвлөлөөс томилохоор зааснаас өөрөөр Гүйцэтгэх зөвлөлийн бусад бүрэлдэхүүнийг аль байгууллагаас хэрхэн сонгох нь тодорхойгүй, хуулийн дээрх заалттай нийцэхгүй байна.

Түүнчлэн, намын Гүйцэтгэх зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө орон гарсан тохиолдолд нөхөн сонгохтой холбоотой зохицуулалт тусгагдаагүй, ямар тохиолдолд чөлөөлөгдөх, огцруулах үндэслэл тодорхойгүй үлджээ.

2.4.Хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3-т “Энэ хуулийн 41.1-д заасан арга хэмжээг авахад хүргэсэн алдаа, зөрчлийг намын орон нутгийн нэгж гаргасан тохиолдолд тухайн асуудлыг нам дүрмээр зохицуулна”, 42.4-т “Энэ хуулийн 42.1-д заасан арга хэмжээг авахад хүргэсэн алдаа, зөрчлийг намын орон нутгийн салбар нэгж гаргах тохиолдолд зохицуулах заалтыг нам дүрэмдээ тусгана” гэжээ.

Харин намын дүрмийн 13.4-т “Улс төрийн намын тухай хуулийн 41.1, 42.1-д заасан зөрчил гаргасан буюу тухайн зөрчил гарахад хүргэсэн үйлдэл, эс үйлдлийг хийсэн намын байгууллагын удирдлагад намын Удирдах зөвлөлийн шийдвэрээр хариуцлага тооцно” гэх боловч хэн ямар хариуцлага хүлээлгэх нь тодорхойгүй орхижээ.

Тухайлбал, хуулийн эдгээр зохицуулалтаас үзэхэд, сонгуулийн төв байгууллага нь намын санхүүгийн тайланг хүлээн авч хянах бөгөөд алдаа зөрчилтэй тайланг ирүүлсэн нам аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд алдаа зөрчлөө арилгах, санхүүгийн тайланг шинэчлэх, төрийн санхүүжилтийн тодорхой хэсгийг дараагийн жилд олгохгүй нөхцөл үүссэн, энэхүү алдаа зөрчлийг намын орон нутгийн нэгж гаргасан тохиолдолд хэрхэн шийдвэрлэхийг намын дүрмээр зохицуулна. Мөн нам нь хуулиар хандив авахыг хориглосон этгээдээс хандив хүлээн авснаа мэдсэнээс хойш ажлын 10 өдрийн дотор тухайн хандивлагч болон сонгуулийн төв байгууллагад энэ тухай мэдэгдэж, хандивыг сонгуулийн төв байгууллагад шилжүүлэх үүрэгтэй байна. Хэрэв хандивыг шилжүүлээгүй бол тухайн нам хууль бусаар авсан хандивыг хоёр дахин өсгөсөн дүнгээр сонгуулийн төв байгууллагад төлөх бөгөөд энэхүү арга хэмжээг авахад хүргэсэн алдаа зөрчлийг намын орон нутгийн салбар нэгж гаргах тохиолдлыг хэрхэн шийдвэрлэхийг намын дүрмээр зохицуулна.

2.5.Хуулийн 27 дугаар зүйлийн 27.13-т “Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг сонгуулийн төв байгууллагын шийдвэрийн дагуу намын төв байгууллагад олгох бөгөөд салбар болон бүтцийн нэгжид хуваарилах асуудлыг намын дүрмээр зохицуулна” гэсний дагуу төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг салбар болон бүтцийн нэгжид хуваарилах шалгуур нөхцөл, хувь хэмжээг намын дүрэмд заах шаардлагатай.

Гэтэл намын дүрмийн 20.1-д заасан “Намын Гүйцэтгэх зөвлөл тухайн жилийн төсвийг батлахдаа үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг салбар болон бүтцийн нэгжид хуваарилж болно” гэж зохицуулсан нь хуулийн дээрх шаардлагад нийцэхгүй байна.

2.6.Намын дүрмийн 1.1-д “ХҮН нам нь Монгол Улсаа 21-р зууны хөгжлийн шинэ эринд гаргах их үйлсийг түүчээлэх, эх орондоо хүмүүнлэг, иргэний, ардчилсан, аз жаргалтай, эрх чөлөөт нийгмийг байгуулах эрхэм зорилгын хүрээнд сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн” гэж зорилгоо тодорхойлсон атлаа дүрмийн 24.1-д “Нам зорилгоо биелүүлсэн гэж үзвэл татан буугдах ба татан буугдах үйл ажиллагааг холбогдох хуулийн дагуу гүйцэтгэнэ” гэж заажээ. Дүрмийн 24.1 дэх заалт нь Иргэний хуулийн 32 дугаар зүйл, Улс төрийн намын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасанд нийцэж буй эсэхийг анхаарах нь зүйтэй.

2.7.Мөн намын дүрэмд хуулийн хориглосон зохицуулалтуудыг, тухайлбал, хяналтын байгууллагын хараат бусаар ажиллах, үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглох талаар, мөн нам нь хуульд заасан орлогыг зөвхөн нэг банкны дансаар хүлээн авах бөгөөд өөр харилцах данстай байхыг хориглох зохицуулалт, орлогыг цахим мөнгөөр хүлээн авахыг хориглох талаар, хориглосон этгээдээс хандив, тусламж, санхүүжилт шууд болон шууд бусаар авахыг хориглох талаар,

сонгуульд нэр дэвших эрх олгохдоо намын гишүүн, дэмжигчээсээ барьцаа, дэнчин болон бусад аливаа хэлбэрээр мөнгө болон мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ өгөхийг шаардах, авахыг хориглох талаар тус тус тусгаагүй байна.

2.8. Намын дүрэм 9 бүлэгтэй байхад дүрмийн 7.3-т “ ... дүрмийн 11-р бүлэгт...” гэсэн нь алдаатай болжээ.

ХҮН намын Ээлжит Их хурлын 2025 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн ИХ/08 дугаар тогтоолоор баталсан намын дүрэм (Шинэчилсэн найруулга)-ийг хуульд нийцээгүй үндэслэлээр бүртгэхээс татгалзаж шийдвэрлэв.

Гурав.Хугацаа тогтоох талаар:

3.1.Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан хугацаанд буюу 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор намын дүрмийг Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн бүртгүүлэхээр өргөдөл ирүүлсэн боловч хуульд нийцээгүйн улмаас тухайн дүрэм нь бүртгэгдээгүй, буцаагдсан намд алдаа зөрчлөө зассаны үндсэн дээр дахин нэг удаа Улсын дээд шүүхэд хандах эрхийг хугацаа тогтоож олгохоор шийдвэрлэсэн.

3.2.ХҮН намын тухайд, дээрх хуульд заасан хугацаанд намын дүрэм (Шинэчилсэн найруулга)-ийг бүртгүүлэхээр Улсын дээд шүүхэд өргөдөл ирүүлсэн боловч тус намын дүрмийн холбогдох заалтууд нь хуульд нийцээгүй талаар энэ тогтоолын хоёр дахь хэсэгт дүгнэсэн болно.

3.3.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд намын дүрмийн зарим заалт хуульд нийцээгүй тохиолдолд зөрчлөө арилгасны дараа дахин хандах, шийдвэрлэх хугацааг тухайлан заагаагүй боловч энэ тохиолдолд Улс төрийн намын тухай хуулийн холбогдох зохицуулалтыг тайлбарлан хэрэглэх үндэслэлтэй гэж үзлээ.

3.4.Тодруулбал, Улс төрийн намын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т “Улсын дээд шүүх намыг бүртгүүлэх өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичигт дараах зөрчил илэрсэн тохиолдолд ... уг зөрчлийг арилгаж, нэмэлт мэдээллийг ирүүлэх тухай өргөдөл гаргагчид мэдэгдэнэ” гэж заасны дагуу иргэдийн эвлэлдэн нэгдэх үндсэн эрхийг хангах үүднээс хуульд заасан хугацаанд өргөдөл гаргасан намд холбогдох зөрчлөө арилган дахин нэг удаа хандах боломжийг олгох нь зүйтэй.

3.5.Иймд, өргөдөл гаргагчид Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т “Намын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, намын даргыг томилсон шийдвэрийг 60 хоногийн дотор Улсын дээд шүүхэд албан ёсоор хүргүүлнэ” гэж зааснаар намын дүрмийн зөрчлийг арилгаж, дахин бүртгүүлэх хугацааг нэг удаа, 60 хүртэл хоногоор олгож байна. Энэ хугацааг өргөдөл гаргагч уг тогтоолыг гардан авснаас хойш тоолж эхэлнэ.

3.6.Тогтоосон хугацаанд зөрчлөө арилгаж, намын дүрмийг бүртгүүлэх өргөдлөө дахин гаргаагүй, эсхүл өргөдөл ирүүлсэн боловч зөрчлөө арилгаагүй бол бүртгэхээс татгалзах бөгөөд ийнхүү татгалзах шийдвэр гарснаар Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан үүргийг

биелүүлээгүй гэж үзэж, Улсын дээд шүүхэд бүртгэлтэй дүрэм нь уг хугацаанаас бүртгэлгүйд тооцогдох бөгөөд ингэснээр хүчин төгөлдөр байдлаа алдах хууль зүйн үр дагавартай болохыг анхааруулж байна.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 17 дугаар зүйлийн 17.6 дахь хэсэгт заасныг баримтлан ХҮН намын даргаар Тогмидын Доржхандыг бүртгэсүгэй.

2.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэгт заасныг баримтлан ХҮН намын дүрэм (Шинэчилсэн найруулга)-ийг бүртгэхээс татгалзсугай.

3.Энэхүү тогтоолыг гардаж авсан өдрөөс хойш намын дүрмийн нэмэлт, өөрчлөлт (Шинэчилсэн найруулга)-ийг бүртгүүлэх өргөдлийг 60 хоногийн дотор дахин нэг удаа ирүүлж болохыг мэдэгдсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Б.УНДРАХ